

## **МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ БҮРТГЭХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “МНХ” гэх)-г улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.МНХ-г улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон энэ журмыг тус тус баримтална.

1.3.МНХ-г улсын бүртгэлд бүртгэх чиг үүргийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

1.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг МНХ байна.

1.5.МНХ-г үүсгэн байгуулах болон мэдээлэлд өөрчлөлт оруулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд цаасан, эсхүл цахим хэлбэрээр хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

### **Хоёр.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх**

2.1.МНХ-г үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг тус тус баримтална.

2.2.МНХ-г үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-т зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1.эрх бүхий этгээд нь гадаадын иргэн бол паспортын хуулбар, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон бүртгэлийн дугаар бүхий баримт бичгийн хуулбар.

2.3.Улсын бүртгэгч МНХ-г бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгаж, ажлын 21 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгэх эсэх шийдвэр гаргана.

2.4.Улсын бүртгэгч энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгах талаар хүсэлт гаргагчид цаасаар, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

### **Гурав.Мэргэжлийн нэгдсэн холбооны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх**

3.1.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална.

3.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан шийдвэр, холбогдох баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

3.3.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

3.3.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, хурлын тэмдэглэл;

3.3.2.МНХ-ны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

3.3.3.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

3.3.4.эрх бүхий этгээд хуралд оролцоогүй тохиолдолд түүнд хурлын зар хүргэсэн талаарх нотлох баримт.

### **Дөрөв.Мэргэжлийн нэгдсэн холбоог өөрчлөн байгуулсныг бүртгэх**

4.1.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлийг тус тус баримтална.

4.2.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

4.2.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, хурлын тэмдэглэл;

4.2.2.МНХ-ны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт.

## **Тав.Мэргэжлийн нэгдсэн холбоог татан буулгасныг бүртгэх**

5.1.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23, 24, 25 дугаар зүйлийг тус тус баримтална.

5.2.МНХ-г татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрийг мэдэгдэлд хавсаргана.

5.3.Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу эрх бүхий этгээд МНХ-г татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дотор баримт бичгийг бүрдүүлэн улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

5.4.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

5.4.1.эрх бүхий этгээдийн шийдвэр;

5.4.2.татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй тухай тодорхойлолт;

5.4.3.МНХ-г татан буулгасан тухайг нийтэд мэдээлсэн баримт.

5.5.Улсын бүртгэгч энэхүү журмын 5.4-т заасан баримт бичиг, мэдээллийг ажлын 21 өдрийн дотор хянаж, улсын бүртгэлд бүртгэх эсэх шийдвэр гаргана.

5.6.МНХ-г татан буугдсан тухай мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэснээр улсын бүртгэлээс хасагдсанд тооцно.

## **Зургаа.Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах**

6.1.Улсын бүртгэгч Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12.2, 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах үндэслэлээр МНХ-г улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

6.2.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд хүсэлт гаргаагүй;

6.2.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан шаардлагыг хангаагүй бол;

6.2.3.улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, засвартай, эсхүл мэдээлэл нь зөрүүтэй, илтэд хуурамч бол;

6.2.4.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлөөгүй бол;  
6.2.5.Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 20.1.10, 20.1.14-т заасан үндэслэл байгаа бол;

6.2.7.эрх бүхий байгууллагаас олгодог холбогдох хуульд заасан зөвшөөрлийг аваагүй бол.

6.3.Улсын бүртгэгч энэ журмын 6.2-т заасан үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг цахимжуулан, хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар архивт шилжүүлнэ.

### **Долоо.Бусад**

7.1.Улсын бүртгэлийн байгууллага Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8.6-д заасны дагуу МНХ-г улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл, тайлбарыг холбогдох<sup>1</sup> этгээдээс гаргуулан авах, шинжээч томилуулан ажиллуулж болно.

7.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5.3.1-д заасан тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй эсэх мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулна.

7.3.Улсын бүртгэгч улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай төрийн бусад байгууллагын мэдээллийг нийтийн мэдээллийн дэд бүтцээс авч баталгаажуулна.

7.4.МНХ-г улсын бүртгэлд бүртгүүлэхэд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 21.1-д заасан улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлнө.

---o0o---

---

<sup>1</sup> Холбогдох этгээд гэдэгт гааль, татвар, статистик, өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон бусад холбогдол байгууллагыг ойлгоно.